

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТООЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: Монгол-Оросын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэг
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: “УБТЗ” ХНН-ийн ажилчдын зуны ажлын хувцас оёж гүйцэтгэх УБТЗ/2020/НТШ/02
ТООЗ 1.2	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: 2020.04.01
ТООЗ 1.3	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц №1 - 1650 хос зуны ажлын гадна орчны хувцас, Багц №2 - 1650 хос зуны ажлын гадна орчны хувцас, Багц №3 - 1618 хос зуны ажлын дотор орчны хувцас, Багц №2 - 1617 хос зуны ажлын дотор орчны хувцас,
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгө
ТООЗ 4.4.(в)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: “үгүй”
ТООЗ 5.2.(б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жилийн 2018, 2019 оны аудитлагдсан тайлан.
ТООЗ 5.2 (д)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл: гэрээ, гэрээг дүгнэсэн актын хамт ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2018, 2019 он/
ТООЗ 5.3 (а)	Борлуулалтын хэмжээ: сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь санал болгож байгаа үнийн дүнгээс багагүй байна. Хэрэв нэгээс дээш багцад оролцох бол багц тус бүрийн нийлбэр дүнгээр тооцно.
ТООЗ 5.3 (в)	Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Өөрийн өмчийн оёдлын машин тоног төхөөрөмжийн жагсаалтыг ирүүлнэ.
ТООЗ 5.3 (д)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон банкнаас авах боломжтой зээлийн нийлбэр: Санал болгож буй ажлын үнийн дүнгээс багагүй байх. /Тендерт шалгарсан тохиолдолд зээл олгоно гэсэн тодорхойлолтыг тооцохгүй/
ТООЗ 6.1	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: Түншлэлийн гэрээ, түншлэгч нь оролцогчийн мөн адил материалыг бүрдүүлсэн байна.
Б. Тендерийн баримт бичиг	